

**ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМАНД ХЭРЭГЖИЖ
БАЙГАА 300МВТ -ИЙН ЦАХИЛГААН СТАНЦ-ЫН ТӨСЛИЙН 2025
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**ААН-ИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:
ЦЭЦЭНС МАЙНИНГ&ЭНЕРЖИ ХХК- 5482046**

Хянасан:

УУБОБ-ын хэрэгжилт, БОМТөлөвлөгөөний асуудал хариуцсан ахлах шинжээч

Танилцсан:

Төв аймгийн БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн

/С.Эрдэнэцогт/

Биелэлтийг тайлагнасан:

ХАБЭАБО хэлтэсийн байгаль орчны мэргэжилтэн

/Д.Даваасүрэн/

Улаанбаатар хот
2025 он

Агуулга

1. Төслийн товч танилцуулга.....	4
1.1 Төслийн нэр: Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний ордыг ашиглах (Бөөрөлжүүтийн тал) төсөл	4
1.2 Төсөл хэрэгжүүлэгч: "Цэцэнс Майнинг энд Энержи" ХХК. Улсын бүртгэлийн дугаар: 9011273046, регистрийн дугаар: 5482046	4
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	5
1.4 Төслийн байршил	5
1.5 Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний ордын нөөц	7
1.6 Уурхайн тээвэр:	7
1.7 Бөөрөлжүүтийн тал хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, нэмэлт тодотголудын танилцуулга	8
2. Бөөрөлжүүтийн талын төслийн талбай орчмын байгаль орчин, нийгмийн төлөв байдал, онцлог	9
2.1 Уур амьсгалын нөхцөл	9
2.2 Газарзүйн бүс бүслүүр	9
2.3 Гадаргын усны нөөц онцлог	9
2.4 Газрын доорхи усны горим, ус ашиглалт	9
2.5 Агаар	10
2.6 Хөрс	10
2.7 Ургамал	10
2.8 Ан амьтан	10
2.9 Дуу шуугиан	10
2.10 Тусгай хамгаалалттай газар нутаг	11
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	13
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	29
6.1 Шимт хөрс	
6.2 Ногоон байгууламж	33
6.2.1 Ажилчдын хотхоны ногоон байгууламж	35
6.2.2 Ажилчдын хотхон орчмын модны арчилгаа, хамгаалалт, усалгаа	36
6.2.3 Ажиллах хүч	43
7. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажил	
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	46
9. Түүх , соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	47
10. Байгаль орчны удирдлагын тогтолцоо	48
11. Эрсдлийн менежментий төлөвлөгөө	
12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	
14. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	
БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ	
14.1 АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ	
14.1.1 Мониторингийн цэг, байршил	
14.1.2 Судалгааны арга, дээж авалт	
14.1.3 Хяналт-шинжилгээний дүн	
Нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) хэмжилтийн үр дүн	
Агаарын бохирдуулагч бодисын хэмжилт үр дүн	

	Дуу шуугианы хэмжилтийн үр дүн.....	
14.2	УСНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ	
14.2.1	Мониторингийн цэг, байршил	
14.2.2	Судалгааны арга, дээж авалт	
14.2.3	Хяналт-шинжилгээний дүн.....	
14.3	ХӨРСНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ	
14.3.1	Мониторингийн цэг, байршил.....	
14.3.2	Судалгааны арга, дээж авалт	
14.3.3	Хяналт-шинжилгээний дүн.....	
	Хөрсний хүнд металлын агууламж.....	
	Хөрсний бичиглэл.....	
14.4	УРГАМЛАН НӨМРӨГ	
14.4.1	Мониторингийн цэг байршил.....	
14.4.2	Судалгааны арга, дээж авалт	87
14.4.3	Хяналт шинжилгээний үр дүн	88
14.4.4	Мониторингийн 1-р цэг.....	91
14.4.5	Мониторингийн 2-р цэг.....	94
14.4.6	Мониторингийн 3-р цэг.....	97
15	АМЬТНЫ АЙМАГ	99
15.1	Мониторингийн цэг байршил, аргазүй:.....	99
16.	Орчны хяналт шинжилгээний тайлангийн дүгнэлт	101
	АШИГЛАСАН МЭДЭЭЛЭЛ, ЭХ СУРВАЛЖ.....	109
17.	Хавсралтууд.....	109

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн тайлангтийн гол зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, оршин суугчдын эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, түүний сөрөг үр дагавар, түүнээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг тогтоох явдал юм.

Төслийн үйл ажиллагааны үед байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг агаар, хөрс, ургамал зэрэгт нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн ургамлан бүрхэвчийн талхлагдал, хөрсийг бохирдол, элэгдлээс хамгаалах арга хэмжээний зөвлөмж, арга зүйг Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн стратеги төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний ордыг ашиглах (Бөөрөлжүүтийн тал) төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: "Цэцэнс Майнинг энд Энержи" ХХК. Улсын бүртгэлийн дугаар: 9011273046, регистрийн дугаар: 5482046

Тусгай зөвшөөрлийн төрөл /Ашигт малмтал/ Дугаар Хүчинтэй хугацаа	MV-020342 Ашигт малтмал ашиглах зөвшөөрөл- 2021 он
	MV-017187 Ашигт малтмал ашиглах зөвшөөрөл- 2032 он
Галын дүгнэлтийн огноо, дугаар	№: 0007790 Огноо: 2023.03.28-2025.03.28 Байршил: Ажилчдын амьдрах хотхон
Орон нутагтай газар эзэмшлийн тухай хийсэн гэрээний огноо, баталсан хуулийн этгээдийн нэр, албан тушаал, байгууллага	Төв аймаг Баян сум
	Дугаар: 0293746 Огноо: 2012.06.13 Зориулалт: Шатахуун түгээх станц
	Дугаар: 0297452 Огноо: 2011.11.29 Зориулалт: Ажилчдын байр
	Дугаар: 0297457 Огноо: 2012.03.22 Зориулалт: Сайжруулсан авто зам
	Дугаар: 0297456 Огноо: 2012.03.22 Зориулалт: Сайжруулсан авто зам
	Дугаар: 0297455 Огноо: 2012.03.22 Зориулалт: Хатуу хучилттай авто зам
	Дугаар: 0297458 Огноо: 2012.03.22 Зориулалт: Төмөр замын зурвас
	Дугаар: 000315088 Огноо: 2012.11.12 Зориулалт: Хатуу хучилттай авто зам
	Дугаар: Э 1404000035 Огноо: 2019.08.02


	Зориулалт: Төмөр зам
	Төв аймаг Баянжаргалан сум
	Дугаар: 000297889
	Огноо: 2015.08.12
	Зориулалт: Цахилгаан станц барих
	Дугаар: 000297890
	Огноо: 2015.08.12
	Зориулалт: Нүүрс боловсруулах үйлдвэр
	Дугаар: 000297888
	Огноо: 2015.08.12
	Зориулалт: Хиймэл нуур байгуулах
	Дугаар: Э-1407000001
	Огноо: 2019.07.05
	Зориулалт: Төмөр зам

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 24, “Парк Плассе, 4-н давхар 402 тоот” Утас: 11316117

Гүйцэтгэх захиралын нэр, утас, цахим шуудангийн хаяг: Д.Мөнхтөр, 11316119, 11316118 munkhtur@tme.mn


Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг: Д.Даваасүрэн, 99142503, Env.expert@tme.mn

Төслийн байршил: Бөөрөлжүүтийн талын уурхайн төслийн талбай нь Төв аймгийн Баян, Баянжаргалан сумдын нутгийг дамнан орших бөгөөд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн MV-020342, MV-017187 дугаартай нийт 1.85 х 1.87 км талбайд өргөрөгийн дагуу сунасан хэлбэртэй 334.13 га талбайг эзлэн оршино. Бөөрөлжүүтийн тал төслийн талбайн төв нь Улаанбаатар хотоос зүүн урагш 106.4 км, Баян сумын төвөөс зүүн хойш 23.3 км, Баянжаргалан сумын төвөөс баруун хойш 27.6 км зайд Цайдам нуурын хөндийд оршино. (Зураг 1).



Зураг1. Бөөрөлжүүтийн талын уурхайн төслийн талбайн байршил

**Эх сурвалж: Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн БОМТ,
Эко Трейд ХХК**



Зураг-2. Уурхайн төслийн талбайн одоогийн байдал

Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний ордын нөөц: Тус ордын төв хэсэгт гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр нөөцийг үйлдвэрлэлийн зэргээр тооцоолон хайгуул, ашиглалтын 3 тусгай зөвшөөрлийн талбай бүрээр хуваан боломжтой В зэргээр 377.26 сая.тн болон бодитой С зэргийн 102.08 сая.тн нөөц гэж ангилан тооцоолсон. Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний ордыг ил уурхайгаар 64 жил ашиглана.

Уурхайн тээвэр:

Дотоод тээвэр: Уурхайн дотоод тээвэрт нүүрсийг уурхайгаас тээвэрлэн нүүрсний агуулахад хураах ажил, хөрсийг уурхайгаас гадаад овоолго хүртэл тээвэрлэх ажлуудыг хамтад нь ойлгоно.

Гадаад тээвэр: Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний уурхайгаас олборлосон нүүрсийг гэрээт тээврийн компаниудад нь 80–100 тн даацтай автомашинаар Мааньт төмөр замын ачих буулгах талбай руу 30 км сайжруулсан шороон замаар тээвэрлэнэ. 2022 онд уулын ажил түр зогссон учраас тээвэрлэлт явагдаагүй болно.

Бөөрөлжүүтийн тал хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, нэмэлт тодотголуудын танилцуулга

Цэцэнс Майнинг энд Энержи ХХК нь Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн Техник эдийн засгийн үнэлгээг 2012 онд боловсруулсан бөгөөд ТЭЗҮ-ийн нэмэлт тодотголыг 2015, 2022 онуудад батлуулсан.

2012 онд Эко Трейд ХХК тус төслийн Байгаль орчин, нийгэм эдийн засгийн суурь судалгааны тайлан, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан (БОНБНҮ)-г боловсруулсан. Түүнээс хойш Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний ордыг ашиглахад орсон өөрчлөлтүүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг цаг тухайд нь тодотгол болгон батлуулж ирсэн. Эдгээр БОНБНҮ-ний нэмэлт тодотголуудын агуулгыг товч танилцуулав.

1. **2011 он, Эко трейд ХХК**-ий боловсруулсан Бөөрөлжүүтийн тал хүрэн нүүрсний ордын дэвсгэр талбайн байгаль орчны геоэкологийн үнэлгээний тайлан
2. **2011 он, Эко трейд ХХК**-ий боловсруулсан Бөөрөлжүүтийн тал хүрэн нүүрсний уурхайн ажилчдын кемпийг барьж байгуулах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан
3. **2012 он, Эко трейд ХХК**-ий боловсруулсан Бөөрөлжүүтийн тал хүрэн нүүрсний орд төслийн төмөр зам тавих байгаль орчин, нийгэм эдийн засгийн суурь судалгааны тайлан
4. **2012 он, Эко трейд ХХК**-ий боловсруулсан Бөөрөлжүүтийн тал хүрэн нүүрсний ордоос Багахангай чиглэлийн төмөр замыг барьж байгуулах, ашиглах таслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан
5. **2012 он, Эко трейд ХХК**-ий боловсруулсан Бөөрөлжүүтийн талын нүүрсний ордоос төмөр замын 1819-р зөрлөг хүртэлх хатуу хучилттай автозам төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан
6. **2012 он, Эко трейд ХХК**-ий боловсруулсан Бөөрөлжүүтийн тал нүүрсний төслийн Байгаль орчин, нийгэм эдийн засгийн суурь судалгааны тайлан
7. **2012 он, Эко трейд ХХК**-ий боловсруулсан "Бөөрөлжүүтийн тал" хүрэн нүүрсний ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөө
8. **2014 он, Эко трейд ХХК**-ий боловсруулсан Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан

9. **2016 он, Эко трейд ХХК**-ий боловсруулсан Бөөрөлжүүтийн нүүрсний уурхайгаас төмөр замын 1819-р зөрлөг хүртэлх хатуу хучилттай автозам төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан
10. **2016 он, Эко трейд ХХК**-ий боловсруулсан Бөөрөлжүүтийн салбар төмөр зам барих төслийн БОННУ-ий тайлан
11. **2022 он, Байгаль-Экологи ХХК**-ий боловсруулсан Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан.

Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга:

Бөөрөлжүүтийн талын төслийн талбайд байгаль орчны төлөв байдлын судалгааг 2011 онд байгаль орчны судалгаа үнэлгээний “Эко Трейд” ХХК гүйцэтгэсэн. Тус судалгааны ажлын хүрээнд гаргасан гол үр дүнгүүдийг дор дэлгэрүүлэн авч үзэв.

Уур амьсгалын нөхцөл: Бөөрөлжүүтийн талын төслийн талбай орчимд агаарын үнэмлэхүй бага температур нь -41°C , үнэмлэхүй их температур нь 39°C хүрдэг бөгөөд үнэмлэхүй их, бага температурын агууриг нь (80.1°C) эрс тэс ялгаатай байдаг. Жилийн дундаж температур нь -1.4°C , хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур -29.5°C , хамгийн дулаан 7 сарын дундаж температур нь 24.6°C байдаг. Баян сумын нутагт жилд дунджаар 220 мм хур тунадас унадаг. Цасан бүрхэвч 11 сарын 06-ны үед тогтож 3 сарын 20-н хүртэл 110 орчим хоног 18 см орчим зузаан цастай байна. Баян сумын агаарын харьцангуй чийг 1 сард 73-78 орчим хувь, 5 сард 44-49 орчим хувь байдаг.

Газарзүйн бүс бүслүүр: Бөөрөлжүүтийн талын төслийн талбай нь Дорнод Монголын тал хээрийн бүсэд Хэнтийн нурууны урд үргэлжлэлийн төгсгөл хэсгийн ойт хээрийн бүсийг тал хээрийн бүсэд шилжих заагт орших Бөөрөлжүүтийн тал хэмээх хөндий болон түүний баруун талаас нийлэх Хөнхөрийн хөндийн уулзвар хэсэгт байрлана. Газрын гадарга нь ерөнхийдөө тэгшивтэр 1370-1430 м, харьцангуй өндрийн ялгаа 60м ба баруунаас зүүн тийш намсаж тогтсон байна. Бөөрөлжүүтийн уурхайн ойролцоох хамгийн өндөр уул нь уг төслийн талбайгаас хойш 3 км зайд орших Үзүүрийн Дэндгэр уул (д.т.д 1541 м), баруун урагш 3 км зайд орших Янсангийн хар толгой (д.т.д 1481 м) юм. Бөөрөлжүүтийн тал төслийн 2215.36 га талбайн 1448.84 га талбай нь Баян сумын нутагт, үлдсэн 766.52 га талбай нь Баянжаргалан сумын нутагт тус тус багтана.

Гадаргын усны нөөц онцлог: Бөөрөлжүүтийн талын төслийн талбайн хэмжээнд байнгын урсацтай гол, горхи байдаггүй. Харин түр урсацтай хуурай сайрууд уг төслийн талбайг хөндлөн огтолно. Сайрын үндсэн урсац нь хаврын шар ус, зуны хур борооны үерийн уснаас бүрдэх бөгөөд уур амьсгал, газрын гадаргын төрх, хур тунадас зэргээс шалтгаална. Хур бороо элбэг жил хонхор, хотгор газарт нуур үүсдэг.

Газрын доорхи усны горим, ус ашиглалт: Бөөрөлжүүтийн талын төслийн талбайд болон түүний ойр орчимд орших нийт 8 худаг байгаагаас хоёр худаг (Хашаат, Довно бууц) талбайн

гадна талд буюу зүүн хойд хэсэгт оршино. Талын төмөрт худаг төслийн талбайн зүүн хойд хэсэгт, Цагаан ус (Худаг-2), Худаг-3, эзэнгүй худаг, Найман хонд (Худаг-1) болон Кэмпийн худаг зэрэг нь төслийн талбайн төв хэсэгт тус тус оршдог. Эдгээр худгийн усны дээжид хийсэн шинжилгээний үр дүнгээс үзэхэд Найман хонд худгийн ус хатуулаг ихтэй, бохирдолтын үзүүлэлт болох аммоний ион, магни, төмөр, хуурай үлдэгдлийн хэмжээ, Цагаан ус худагт магни, Хашаат, Талын төмөр худгуудад магни, төмөр, фторын хэмжээ тус тус Монгол Улсын ундны усны стандарт (MNS 900:2005)-ад заасан хэмжээнээс их байдаг тул ундны эх үүсвэрт хэрэглэхэд тохиромжгүй байна. Зайлшгүй тохиолдолд цэвэршүүлж хэрэглэх шаардлагатай. Харин химийн бүрэлдэхүүнээрээ Найман хонд, Хашаат, Талын төмөрт, Кэмпийн худгуудын ус гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, хатуувтар устай бол Цагаан ус худгийн ус гидрокарбонатын ангийн, магнийн бүлгийн, 2-р төрлийн бага эрдэсжилтэй, хатуу устай байна.

Агаар: Бөөрөлжүүтийн тал төслийн талбайн ойр орчимд нийт 5 цэг сонгон агаарын нэгж эзэлхүүн дэх PM2.5 тоосонцорын хэмжээг тодорхойлсон байна. Судалгааны талбайд нарийн ширхэглэгт (PM2.5) тоосонцоруудын хэмжээ агаарын чанарын зөвшөөрөгдөх дээд хэмжээн болох 0.05 мг/м³-ээс 1.8-2.5 дахин бага гарсан байна.

Хөрс: Бөөрөлжүүтийн тал төслийн талбайд нийт 6 хэв шинжийн хөрсийг ялгаж дээж аван шинжилгээнд өгсөн. Хөрсөн бүрхэвчийн шинжилгээний дүнгээс үзэхэд хөрсний шим тэжээлийн бодисын агууламж нь дундаас дээд зэрэг хангамжтай байна. Энэ нь байгалийн болон таримал ургамлын шим тэжээлийн хувьд дунд зэргийн хангамжтай байна. Хөрсний орчин дунджаар pH 7.09 буюу сул шүлтлэг байна. Харин фосфор, кали хоёроор хангалттай. Шимт хөрсийг хуулахдаа дунджаар 20 см гүнтэйгээр хуулж болно.

Ургамал: Бөөрөлжүүтийн тал төслийн талбайд хийсэн ургамлан нөмрөгийн хээрийн судалгааны үр дүнд төслийн талбайд 25 овог, 59 төрөлд хамаарагдах 79 зүйл гуурст дээд ургамал бүртгэгдсэн байна.

Ан амьтан: Бөөрөлжүүтийн тал төслийн талбайд хийгдсэн амьтны аймгийн судалгаагаар 22 зүйлийн шувуу, 7 зүйлийн хөхтөн зэрэг нийт 29 зүйлийн сээр нуруутан амьтад бүртгэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн шувуудын зүйлийн бүрэлдэхүүнд Монгол улсын болон Азийн улаан ном, Ховор шувуудын жагсаалтанд орсон зүйл тэмдэглэгдээгүй бөгөөд Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг худалдаалах тухай олон улсын конвенц буюу CITES-ийн II хавсралтад бүртгэгдсэн шилийн сар, сохор элээ, идлэг шонхор, өвөгт тогоруу тэмдэглэгджээ. Хөхтөн амьтдын бүртгэлээс харахад бүс нутгийн хэмжээнд устаж болзошгүй Монгол тарвага, цагаан зээр, ховордож болзошгүй шар үнэг, хярс үнэг, саарал чоно тэмдэглэгдсэн байна.

Дуу шуугиан: Бөөрөлжүүтийн тал төслийн талбайд нийт 108 цэгт дуу шуугианы хэмжилт хийсэн ба 0.10-51.50 дБа хэмжээтэй гарсан байна. Дуу чимээний түвшин зарим үед өндөр гарсан шалтгаан нь тухайн салхи шуурга ихтэй байсан зэрэг байгалийн хүчин зүйл нөлөөлжээ. Төслийн талбайд өндөр давтамжтай дуу чимээ үүсгэх эх үүсвэрүүд байхгүй боно.

Тусгай хамгаалалттай газар нутаг: Бөөрөлжүүтийн талын төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь улсын тусгай хамгаалалттай Нагалхааны байгалийн нөөц газраас 33 км, орон нутгийн хамгаалалттай Цайдам нуур (Их цайдам нуур)-аас 7 км (XV-17023 лицензийн талбайгаас), 16 км (MV-17187 лицензийн талбайгаас), Элэгний цант рашаанаас 31.3 км, Нүхэн булгаас 39 км, Элэгний рашаанаас 37.5 км зайтай оршдог. Тус төслийн талбайн ойролцоо Ээж хад (61.5 км), Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар (66 км)-ын ШЧГ байдаг. Мөн уг хүрэн нүүрсний ордын талбайд хамгийн ойр орших усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс нь талбайн зүүн хойд захаас зүүн зүгт 4.3 км-т, зүүн урд захаас зүүн урагш 8.6 км-т тус тус оршино

БҮЛЭГ 1. 2025 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Уулын ажлын гүйцэтгэл

Хийгдэх ажил		Талбай/га/	Хэсэглэл		Талбай/га/	Хэсэглэл
Олборлолт - Талбай /га/ - Эзэлхүүн /мян.м ³ /	2025 оны төлөвлөлт	12 4800	-	2025 оны биелэлт	11.3 4800	-
Техник - Талбай /га/ - Эзэлхүүн /мян.м ³ /		Тус онд техникийн нөхөн сэргээлт төлөвлөөгүй	-		2.2 3360	-
Биологи - Талбай /га/ - Ойжуулалт /мод. ш/ - Олон наст /кг/		Тус онд биологийн нөхөн сэргээлт төлөвлөөгүй			2.2 400 198	-

2025.10.20-ны байдлаар

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл:

Бөөрөлжүүтийн тал төсөл хэрэгжсэнээр эхний 1 жилд ойролцоогоор 118.8 тн/жил хүртэл тоосжилт үүсэхээр байна. Үүний гол эх үүсвэр нь ил уурхай, уурхайн гадаад овоолго, шимт хөрсний овоолго, нүүрсний агуулах, уурхайн дотоод зам, ил задгай хөрснөөс хийссэн тоос шороо нь орчны агаарыг бохирдуулах нэг эх үүсвэр болж болзошгүй. Бөөрөлжүүтийн уурхайн усжилт ихтэй байдаг онцлог нь тоосжилтын хэмжээг багасгах эерэг талтай юм.

Шинж чанар: Хуурайшилт ихтэй ялангуяа хавар, намрын улиралд сул хөрс, шороо салхинд хийсч ойр орчны агаарыг тоосоор бохирдуулдаг. Тоос нь нүдэнд үл үзэгдэхээс үзэгдэх, ус үл нордог хүртлэх хэмжээтэй хөрс, шорооны нийлмэл шинж чанартай байна.

Эх үүсвэр:

- Ил уурхай, уурхайн гадаад овоолго, шимт хөрсний овоолго, нүүрсний агуулах, уурхайн дотоод зам талбай
- Үржил шимт болон хөрс, нүүрсийг буулгах, тээвэрлэх, овоолго хийхэд үүсэх тоос

Тархалт: уурхайн талбай

Нөлөөлөлд өртөх зүйлс: тоосжилт өндөртэй ажлын байранд байгаа хүмүүс, төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын тархалтын загварчлалыг боловсруулан хяналт тавьж ажилласан.

Төслийн хэрэгжилтийн явцад хөрсөнд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн ашиглалтын явцад тодорхой хэмжээний газар эвдрэлд орж унаган төрхөө алдах хөрс хуулах, шинээр зам гаргах зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад хөрс эвдрэхийн зэрэгцээ түүний үржил шим алдагдах, элэгдэлд өртөх зэргээр сөрөг нөлөө үүсэх нөхцөлтэй. Ашиглалтын эхний жил буюу 2017 онд уулын ажлыг 13.82 га талбайд 60 м хүртэл гүнд хийж, нүүрсний хамгийн дээд давхаргаас олборлохоор төлөвлөсөн боловч 2017 оны 6 дугаар сард хөрс хуулах ажил эхэлсэн учир энэ төлөвлөгөөндөө хүрээгүй 2018 оноос үргэлжлүүлэн талбайн үржил шимт хөрсийг хуулж, овоолсон ба 2019, 2020 онуудад шимт хөрсний овоолго үржил шимийг алдагдуулахгүй байх зорилгоор гадаргууг ургамалжуулах ажил хийгдэж 2021, 2022 онуудад нэмэлт тарилт болон арчилгаа усалгааг тогтмол хийж ажиллаж байна.

Шинж чанар: шинээр ашиглагдах талбайн үржил шимт хөрс бүрэн хуулагдаж, газрын хэвлийд хонхор үүсэх бөгөөд газрын гадарга дээр овоолго бий болох зэргээр газрын ландшафтын өөрчлөлт бий болно.

Эх үүсвэр: уурхайн үйл ажиллагаа, барилгын ажил

Нөлөөлөлд өртөх зүйлс: тухайн орчны хөрс, ургамал, амьтан, Хөрсний чанарын хяналт шинжилгээг жил бүр тодорхой давтамжтай хийж ирсэн.

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт:

Хүснэгт-1. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, үргэлжлэх хугацаа

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Зайлшгүй ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн цар хүрээ	Нөлөөллийн эрчим	Нөлөөллийн үргэлжлэх хугацаа
Газрын гадарга, хэвлий	Ил уурхайн карьер үүсгэснээр газрын гадарга, хэвлийн хэлбэр дүрс өөрчлөгдөх,	Ил уурхайн ам	Их	Энэхүү төлөвлөгөө хэрэгжих хугацаанд
	Шатах тослох материалын агуулах, засварын газар, машины зогсоол зэргээс шатах тослох материал алдагдах, өнгөн хөрсийг бохирдуулах улмаар газрын хэвлийг бохирдуулж болзошгүй	Шатах тослох материалын агуулах, засварын газар, машины зогсоол, түүний орчимд	Бага	Энэхүү төлөвлөгөө хэрэгжих хугацаанд
	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, овоолго үүсгэхэд газрын гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх	Үржил шимт хөрсний овоолгын талбай	Бага	Энэхүү төлөвлөгөө хэрэгжих хугацаанд
	Олон салаа зам үүсгэх болон хучмал зам тавихад газрын гадарга эвдрэх	Төслийн талбайн хүрээнд олборлолт явагдаж байгаа	Дунд	Энэхүү төлөвлөгөө хэрэгжих хугацаанд

Агаарын чанар	Үржил шимт өнгөн хөрсийг ачих, буулгах, тээвэрлэх, овоолго хийхэд,	Үржил шимт хөрсний овоолго	Дунд	Ажлыг гүйцэтгэх хугацаанд
	Бөөрөлжүүтийн талын нүүрсний уурхайгаас уурхайн захиргаа хүртэл 3.5 км зам, төслийн талбайд байгаа гүний цооног, хайгуулын суваг, хяналт шинжилгээ хийх цэгүүд зэрэг уурхайн бусад барилга байгууламжуудыг холбосон шороон замаар зорчиж буй тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнөөс үүдэн тоосжилт үүсч агаарт агуулагдах тоосонцорын хэмжээг нэмэгдүүлнэ.	Төслийн талбайн хүрээнд		Ажлыг гүйцэтгэх хугацаанд
	ШТС-ын үйл ажиллагаанд доголдол эвдрэл гарсан тохиолдолд ууршилт үүсч агаар бохирдулах	Тодорхойлох боломжгүй	Дунд	Энэхүү төлөвлөгөө хэрэгжих хугацаанд
Газрын доорхи ус	ШТМ-ын асгаралтаас, нуруулдан уусгалтын доголдлоос бохирдуулж болзошгүй	Төслийн талбайн хүрээнд	Бага	Энэхүү төлөвлөгөө хэрэгжих хугацаанд

Хөрсөн бүрхэвч	ШТМ асгарах, химийн бодис, хог хаягдлаар бохирдох, эвдрэлд өртөх, доройтох	Амьтны аймаг	Дунд	Энэхүү төлөвлөгөө хэрэгжих хугацаанд
Амьтны аймаг	Уурхайн талбайд БОНБНУ болон суурь судалгаагаар ховор, нэн ховор амьтан тогтоогдоогүй болно			
Тусгай хамгаалалтанд газар нутаг	Төслийн талбайн нутаг дэвсгэр, түүний ойролцоо улсын тусгай хамгаалалтанд газар нутаг байхгүй болно.			

2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН:

Төв аймгийн Баян сумын нутагт орших Бөөрөлжүүтийн тал MV-020342, MV-017187 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд нийт **Таван зуун найман сая хоёр зуу арван таван мянга дөрвөн зуу (508 215 400)** төгрөг зардлыг зарцуулсан байна.

Хүснэгт 2. БОМТ-ийн биелэлтийн тайлангийн зардалын задаргаа

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	Төв аймаг /мян.төг/	Тайлбар
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан	31673.7	
2.	Осол эрсдлийн менежментийн тайлан	5000.0	
3.	Нөхөн сэргээлтийн тайлан	132695.8	ТНС-53393.8 БНС-79302.0
4.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний тайлан	135450.0	Үйл ажиллагааны зардалд хамаарна.
5.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор - олгох арга хэмжээний тайлан		


6.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга - хэмжээний тайлан	
7.	Хог, хаягдлын менежментийн тайлан	10500.0
8.	Химийн бодисын эрсдэлийн - менежментийн тайлан	
9.	Удирдлага зохион байгуулалтын тайлан	12000.0
10.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	
11.	Байгаль орчны менежментийн Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг олон нийтэд байгууллагын тайлагнасан талаарх тайлан төсөвт багтсан. Аймаг, нийслэлийн засаг даргын	
12.	шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	
	2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	508215.4


БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тухайн төсөл хэрэгжих орчны өнөөгийн төрх байдал, БОННУ-ээр тодорхойлогдсон болзошгүй болон зайлшгүй сөрөг нөлөөллүүдийг тусгаснаас гадна менежментийн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүд болох дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэргийг дэлгэрэнгүй авч үзсэн.


Хүснэгт-2. Болзошгүй болон зайлшгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Болзошгүй болон зайлшгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зарцуулсан зардлын хэмжээ (мян.төг)	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт
Газрын гадарга ба хэвлий	Тээврийн хэрэгсэл, засварын газар, ШТС-аас ШТМ алдагдаж газрын гадарга хэвлийг бохирдуулах	Засварын газарт ашигласан тосыг ангилан ялгаж түр хадгалах танканд байрлуулан, орчныг стандартын дагуу бетоноор хучиж ашигласан тос боловсруулах үйлдвэрт гэрээний дагуу нийлүүлсэн.	Сар бүр	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Хог хаягдлын тухай хууль холбогдох стандартын дагуу, аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, шатаах, устгах тусгай зөвшөөрөл бүхий төвлөрсөн байгууламж болох “Элемент” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу доорх хог хаягдлыг устгалд оруулсан.  
	Аюултай хог хаягдлыг анилан ялгаж зориулалтын цэгт хадгалаагүйгээс хөрс, усан орчин бохирдох	ТМ-аар бохирдсон хөрсийг, саармагжуулах зориулалт бүхий 3*4 харьцаатай цэг байгуулан бүх төрлийн аюултай хог хаягдлыг цуглуулж байна.	Тогтмол	22.000.0	Засварын төвд аюултай хог хаягдал цуглуулах, ангилан ялгах цэгийг 4 ангилалтай байгуулсан. 

	Үржил шимт хөрсний овоолго үүсгэх явцад газрын гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх	Шимт хөрсний овоолгоос дээж авч хөрсний агрохимийн чанарын шинжилгээ хийлгэж нөхөн сэргээлтийн стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг үнэлнэ.	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Ил уурхай, хаягдал чулуулаг, дэд бүтэцийн талын үржил шимт хөрсийг 0,3 метр зузаантайгаар хуулж, шимт хөрсний овоолго байгуулж шимт хөрсний овоолгын орой хажууг хэлбэржүүлэн нягтаршуулж MNS 5916:2008 стандартын дагуу байршуулсан.  “Монгол улсын стандарт (MNS 5916:2008) Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт.”
Ажилчдын хотхон болон уурхайн талбайд хог хаягдлыг замбараагүй хаях, хөрс бохирдуулах	Шинээр овоолго үүсгэсэн талбайд самбар байршуулах.		Тухайн онд	Тухайн жилийн үйл ажиллагааны зардалд тусгагдсан.	
		Ажилчдын хотхон болон уурхайн ахуйн хог хаягдалын цэг дээр нэмж ангилан ялгалтын хогийн савууд байршуулах.	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Ажилчдын хотхон болон Засварын төвд хог хаягдлыг ангилан ялгах хогийн савуудыг байршуулсан.

					
Шатах тослох материалын агуулах, засварын газар, машины зогсоол зэргээс шатах тослох материал алдагдах, өнгөн хөрсийг бохирдуулах улмаар газрын хэвлийг бохирдуулж болзошгүй	Шатах тослох материалын асгаралтаас урьдчилан сэргийлэх сургалтуудыг зохион байгуулах.	Улирал бүр	2000.0	Шатах тослох материалын асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралтын үед авах арга хэмжээний талаарх сургалтыг нийт ажилчдад зохион байгуулсан.	 


Агаарын чанар	Хучилтгүй замаар тээврийн хэрэгсэл зорчиж тоосжилт үүсгэснээр агаарын чанарт нөлөөлөх, Хатуу ойр орчмын хөрс, ургамлан нөмрөгт нөлөөлөх	Засаж сайжруулсан замаас өөр зам гаргахгүйн тулд тэмдэгжүүлэх, ухуулах самбар байрлуулж зам дээр гарч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлнэ.	Тогтмол	ХАБЭА-н зардалд тусгагдсан	Монгол улсын замын хөдөлгөөний журмын дагуу уурхайн дэд бүтэц, технологийн замаас өөр шаардлаггүй тохиолдолд дур мэдэж зам гаргахгүй байх, шаардлагатай тохиолдолд тодорхой эрх бүхий албан тушаалтнуудын зөвшөөрөл бүхий гарын үсэгтэй “Газар хөндөх зөвшөөрөл”-ийн маягтын хуудас бөглөн мөрдлөг болгон ажиллаж байна.
	Уурхайн бүх авто тээврийн хэрэгсэл болон өөрөө явагч хэрэгслийн агаарт гаргах хаягдалд ноогдуулах төлбөрийг төлөх	Агаарын тухай хуульд заагдсны дагуу автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигчийн татварыг жил бүр автотээврийн газарт тушаасан.	Тайлант онд хамаарна	673.7	2025 онд нийт 51 тээврийн хэрэгслийн татвар төлсөн.  Скриншот дүгнэлт: Голомт Банк-аас 2025 оны зам татвар төлсөнийг баталж байгаа. Банкны гүйцэтгэлийн баримт баримт.

	Уурхайн технологийн зам, уурхайн хүнд даацын тээврийн хэрэгсэл зорчих технологийн замуудаас тоосжилт үүснэ	Технологийн зам дагуу хурдны хязгаарлалтын тэмдэг тэмдэгдэглэгээ 40км хурдтай-8, 60км-7, 20 км- 5 ширхэг нийт 20 ширхэг байршуулсан.	Тайлант онд хамаарна	20 ш* 350.0= 7000.0	
Газрын доорх ус	Уурхайн захиргаа, уурхайн ажилчдын хотхоны бохир усыг түр хуримтлуулах явцад алдагдан газрын хэвлий газрын доорх усыг бохирдуулж болзошгүй	Ажилчдын хотхоны бохирыг байгальд ээлтэй эко байдлаар шийдэх.	2025 оны 2-р улиралд багтаан	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Ариутгах татуургын сүлжээнд хаягдал ус нийлүүлэх шинэчилсэн стандарт MNS 6561:2024 дагуу ажилчдын хотхоноос үүсэх хаягдал бохир усыг цэвэрлэх бага оврын байгууламжыг хийсэн. Хүчин чадал 80 м3/хоног 
	Ил уурхайн ус шавхалтаас шалтгаалан	Газрын доорх усны хяналт, шинжилгээний			

	газрын доорх усны түшин доошлох	хөтөлбөрт тусгагдсан малчдын гар худгуудын түвшний хяналт, усны чанарын шинжилгээг улиралд нэг удаа хийнэ.			
		Ил уурхайгаас шүүрэх усыг шавхан зайлуулах ба уг усыг технологийн хэрэгцээнд ашиглах ба илүүдэл усыг холбогдох стандарт нийцүүлэн байгальд хаях			Тайлант хугацаанд Цахилгаан станцын төсөл эхлээгүй байгаатай холбогдуулан ил уурхайгаас шүүрэх усыг технологийн хэрэгцээнд ашиглаагүй байгаа бөгөөд тодорхой хэмжээгээр уурхайн дэд бүтэц, технологийн замын усалгаанд ашиглаж байна. Шавхан зайлуулж байгаа усыг БОННУ тусгагдсаны дагуу (Хонхор нуур) Хар нуурт хуримтлуулан илүүдэл усыг “Усан орчны чанарын стандарт MNS 4586:1998 ”, “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх хаягдал усны стандарт MNS 4943:2015 ”. “Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 6148 : 2010. ” нийцүүлэн хаяж байна. ОХШ-ий хөтөлбөрөөс үзнэ үү.
Гадаргын ус	ШТМ алдагдаж гадаргын усыг бохирдуулах	Уурхайн ШТС, засварын газар зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон уурхайн хүнд машин техник, тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгах, ШТМ			Газрын тосны бүтээгдэхүүний хууль, Нэгдүгээр бүлэг, 2 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын тухай хууль тогтоомж 2.1, 2,2-зааснаар автобензин, дизел түлш, ШТМ-ыг стандартын шаардлага хангасан зориулалтын сав, агуулахад хадгалаж савны бүрэн бүтэн байдалд 7 хоног тутам хяналт тавьж ажилладаг.

		алдагдсан тохиолдолд бохирдсон хөрсийг саармагжуулах			ШТМ алдагдах үед яаралтай авах арга хэмжээ болох аваарын байдлын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө болон байгаль орчны хяналтын маягт бөглөн мөрдөлг болгон ажилладаг.
		Шатах, тослох материалыг стандартын шаардлага хангасан, зориулалтын сав, агуулахад хадгалах; алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж төлөвлөсөн байх	Тайлант хугацаанд	-	
Ургамалан бүрхэвч	Хөрс хуулалт, нүүрс болон хөрс ачих, буулгах, мөн тээвэрлэх үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын улмаас ургамлын фотосинтезийн эрчим буура	Уурхайн дотоод замын усалгааг тогтмолжуулах, зориулалтын бус замын хөдөлгөөнийг хориглох, тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг тогтоох (60 км/цаг болон түүнээс бага хурдтай яваа тээврийн хэрэгслийн үүсгэх тоосны хэмжээ бага байдаг) ОХШХ-т	Тайлант хугацаанд		Тайлант хугацаанд шимт хөрсний талбайд стандартын дагуу шимт хөрсний овоолго-2 дээр стандартын дагуу шимт хөрсийг төвлөрүүлсэн. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн

		тусгагдсанаар ургамлын мониторингийн ажлыг тогтмол хийж гүйцэтгэх			дагуу ургамалан нөмрөгийн 13 цэгт хяналт шинжилгээний ажил хийгдсэн. ОХШХ хэсгээс дэлгэрэнгүйг үзнэ үү. 
	Шатах тослох материал (ШТМ) алдагдсанаас хөрс бохирдон ургамлын физиологийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж болзошгүй	Шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх, хаягдлыг цуглуулж цэвэрлэн эргүүлж ашиглах арга хэмжээг төлөвлөх, бохирдсон хөрсийг цэвэрлэх, зайлуулах арга хэмжээг авсан.	Тогтмол	ХАБЭАБО болон Засварын хэлтсийн зардалд хамаарна	Аюултай хог хаягдал цуглуулах цэгийг байгуулж бохирдсон хөрсийг цуглуулан саармагжуулах арга хэмжээ авч байна. 
Ан амьтан	Бөөрөлжүүтийн талбайн хүрэн нүүрсний ордын талбайн ойр орчим хууль бус ан агнуур хийж болзошгүй	Уурхайд ирж буй хүн бүрт буу, хавх, галт зэвсгийн шалгалт, хууль бус агнуур хийхгүй байх талаар уурхайн дотоод дүрэмд тусган мөрдөж ажиллуулах	Тогтмол	-	

	Тээврийн хөдөлгөөн, дуу чимээнээс амьтдын шилжилт хөдөлгөөн багасах	Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс гарах дуу чимээний түвшинг үйлдвэрлэгчээс өгсөн хягаарт барих, засвар үйлчилгээг тогмтол хийх		-	замын трансийн дагуу байршуулсан анхааруулах тэмдэгүүд
Физик	Хүнд даацын машин техникүүдийн хөдөлгүүрээс гарах доргио чичиргээнээс нүхэнд амьдардаг мэргэч амьтад дайжих, нутгийн иргэдийн тав тухтай байдлыг алдагдуулж болзошгүй.	Ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрээс гарах дуу чимээ нь үндэсний стандартад нийцэж байх.		-	Уурхайн хүнд болон хөнгөн тээврийн хэрэгсэлүүдэд засварын хэлтэсийхэн тогмтол үзлэг шалгалт, засвар үйлчилгээг хийдэг. 
		Чимээ шуугиантай холбогдон гарсан гомдол саналыг тухай бүр бүртгэн авч, хариу арга хэмжээ авч байна. Ялангуяа чимээ шуугиан ихтэй үйл ажиллагааг зөвхөн өдрийн цагаар явуулна.		-	
Нийгэм эдийн засаг	Төслийн үйл явцад хүн амын төвлөрөл нэмэгдэн эмх замбараагүй байдал бий болох, архидаг согтуурах	Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, ажлын байранд баримтлах ёс зүй, хариуцлагын тогтолцоог уурхайн дотоод журам, тухайн		-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс гадна Хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн ажлын хүрээнд орон нутгын малчидтай хамтран худагаас усны дээж авч шинжилгээнд өгөн ажиллаж байна.

	улмаар хэргийн шинжтэй үйлдлүүд болзошгүй	гэмт гарч	ажилтантай байгуулах гэрээ зэрэгт тодорхой тусгасаныг сайжруулж уурхайн удирдлага зохион байгуулалтын хүрээнд Хянаж ажилласан.			
Нийт зардал						31673.7


БҮЛЭГ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 онд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 2.2 га талбайд 336.0 мян м³ эзэлхүүнтэй ажил хийж гүйцэтгэсэн.

Нөхөн сэргээлтийн зардлын задаргаа:

2025 онд хийгдэх нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ болон зардлыг шороон ордын нөхцөлд нөхөн сэргээлт хийх Монгол улсын стандарт MNS 4918:2000 Байгаль Орчины Яам ба Үйлдвэр Худалдааны Ямны сайдын хамтарсан тушаал 222/109-н зардлын үнэлгээ, заавар батлах журмын дагуу тооцлоо.

Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний ил уурхай нь хөрс хуулалт ихтэй устай, уул техникийн хүнд нөхцөлд ажиллаж буй уурхайд хамаарна. Иймд нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээний 2 дахь баганы үзүүлэлтийг ашиглан дараах байдлаар нөхөн сэргээх ажилд зарцуулагдах зардлын хэмжээг тогтоов.



2025 онд техникийн нөхөн сэргээлтийг 2.2 га, эзэлхүүн - $(336.0 \times 1.1 = 369.6)$ 369.6 мян.м³ ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 6. Бульдозероор тэгшлэх ажлын зардал (D8R бульдозер)

Зардлын нэр	Томъёо	Тайлбар
Тэгшлэх ажлын хэмжээ: - Эзэлхүүн м ³ - Талбай м ²	$V_{пл1} = S_{нийт} * h * k_c$ $V_{пл1}$-тэгшлэх ажлын эзэлхүүний хэмжээ, м³ S-тэгшлэх талбай, м² h-тэгшлэх хөрсний зузаан, см k-сийрэгжилт тооцох коэффициент	$V_{пл1} = 2.2 * 10000 * 0.2 * 1.0$ $= 4400 \text{ м}^3$ $= 2.2 * 10000 = 22000 \text{ м}^2$ $S_{нийт}$
Талбай тэгшлэх үеийн бульдозерийн бүтээл, м ² /цаг	$Q_u = \frac{3600 * L * (l_x \sin \gamma - b) * k_{ца}}{n * \left(\frac{l}{v} + t_g \right)}$	$Q_u = \frac{3600 * 250 * (1.17 \sin 30 - 0.4) * 0.85}{2 * \left(\frac{250}{100} + 60 \right)} = 1132.2 \text{ м}^2 / \text{цаг}$
Нийт ажиллах цаг:	$T = \frac{S_{нийт}}{S_T * k_{экс}}$	$T = \frac{22000}{1132.2 * 0.9} = 17.4 \text{ цаг}$
Түлш, ШТМ-ын зардал:	$C_{дт} = T * TЗ_u * 1.15 * P_{дт}$ $C_{дт}$- Түлш, ШТМ-ын хэрэгцээ $TЗ_u$-цагт зарцуулах түлшний норм 1.15-ШТМ-ын түлшний зардалын 15%-р $P_{дт}$-1л дизель түлшний үнэ, 3050төг	$C_{дт} = 17.4 * 50 * 1.15 * 3.1 = 3101.5 \text{ мян.төг}$
Сэлбэг:	$C_{сэ} = XO_{буль} * k * t / T_k$	$C_{сэ} = 180000.0 * 0.1 * 17.4 / 45.55 = 68759.6 \text{ мян.төг}$
Цалингийн зардал	$C_u = T * H_u$ T-хугацаа C_u -цагийн цалин 21.428	$C_u = 17.4 * 21.428 = 372.8 \text{ мян.төг}$
НДШ	$C_{ндш} = C_u * 0.13$	$C_{ндш} = 372.8 * 0.13 = 48.4 \text{ мян.төг}$
Элэгдлийн зардал	$C_{эхш} = XO_{буль} * H_u * t / T_k$	$C_{сэ} = 1800000.0 * 0.1 * 17.4 / 45.55 = 6875.9 \text{ мян.төг}$
Нийт бульдозерийн зардал	$C_{нийт.буль} = 3101.5 + 6875.9 + 372.8 + 48.4 + 6875.9 = 17274.5 \text{ мян.төг}$	

1 м ² болон 1 м ³ чулуулгыг хэлбэржүүлэх, хэлбэржүүлэх ажлын өөрийн өртөг	- Талбайгаар $a_{пл} = C_{нийт.буль} / s_{нийт}$ - Эзэлхүүнээр: $a_{пл} = C_{нийт.буль} / v_{нийт}$	$a_{пл} = 17274.5 / 2.2 = 7852.0 \text{ төг/га}$ $a_{пл} = 17274.5 / 22000 = 785 \text{ төг/м}^3$
--	--	--

Тэгшилсэн талбайг шимт хөрсөөр хучих ажлын зардал:

Тэгшилсэн талбай 22000 м² талбайг 20 см хөрсөөр хучихад $22000 * 0.2 * 1.05 = 4620 \text{ м}^3$ шимт хөрс хэрэгтэй.

Хүснэгт 7. Шимт хөрсийг овоолгоос утгуурт ачигчаар ачиж, тээвэрлэх ажлын зардал

Үзүүлэлт	Томъёо	Тооцоолол, тайлбар
Ачиж тээвэрлэх ажлын хэмжээ	$V_n = S_i * h * K_c$	$V_n = 22000 * 0.2 * 1.05 = 4620 \text{ м}^3$
Утгуурт ачигчийн ачиж тээвэрлэх ажлын цагийн бүтээл	$Q_{уАч} = \frac{3600 * K_{ца} * E_{ам} * K_{yo} * \gamma}{\left(t + 3.6 * \left(\frac{L_a}{V_a} + \frac{L_x}{V_x} \right) + t_B \right) * K_c}$ - утгуурт ачигчийн нэг цагийн бүтээл, м³ $K_{ца}$ - цаг ашиглалтын коэф $K_{уд}$ - утгуур дүүргэлтийн коэф (0.8-1.2) t - ажлын мөчлөгийн хугацаа $t = 87.8 - 10.65 q_a + 0.52 q_a^2$ q_a - ачигчийн даац, тн L_a, L_x - ачаатай болон хоосон явах тээвэрлэлтийн зай, м V_a, V_x - ачаатай болон хоосон явах хөдөлгөөний хурд, м/сек $E_{ам}$ - тээвэрлэх үеийн утгуурын багтаамж, м³ γ - тээвэрлэх хөрсний нягт, т/м³ t_b - буулгах хугацаа, K_c - сийрэгжилтийн коэффициент	$t = 87.8 - 10.65 * 5 + 0.52 * 5^2 = 45.55$ $Q_{уАч} = \frac{3600 * 0.85 * 3 * 1.1 * 1.8}{\left(45.55 + 3.6 * \left(\frac{100}{11.5} + \frac{100}{16} \right) + 3 \right) * 1.05} = 159.5$
Нийт ажиллах цаг	$T = \frac{V_n}{Q_{уАч}} * K_{экс}$ T - тухайн ажлын гүйцэтгэх цаг $P_{ц}$ - утгуурт ачигчийн нэг цагийн бүтээл, м³ $K_{экс}$ - цаг ашиглалтын коэф	$T = 4620 / 159.5 * 0.8 = 23 \text{ цаг}$

Түлш, ШТМ-ын зардал	$C_{дт} = T * TЗ_{ц} * 1.15 * P_{дт}$ С_{дт}- Түлш, ШТМ-ын хэрэгцээ ТЗ_ц-цагт зарцуулах түлшний норм 1.15-ШТМ-ын түлшний зардалын 15%-р P_{дт}-1л дизель түлшний үнэ, 3050төг	$C_{дт}=23*15*1.15*3.1= 1229.9 \text{ мян.төг}$
Сэлбэг	$C_{сз} = XO_{ут.ач} * k * t / T$ С_{сз}-сэлбэгийн зардал ХО_{ут.ач}-утгуурт ачигчийн үнэ k-сэлбэг тооцоо хувь хэмжээ	$C_{сз}=170000.0*0.1*23/45.55= 8583.9 \text{ мян.төг}$
Цалингийн зардал	$C_{ц} = T * Ц_{ц}$ Т-хугацаа Ц_ц –цагийн цалин 17120мян.төг	$C_{ц}=23*17.120= 395.8 \text{ мян.төг}$
Нийгмийн даатгалын шимтгэл	$C_{ндш} = C_{ц} * 1.13$ Цалингийн сангийн 13%-иар НДШ тооцно	$C_{ндш}=395.8 * 0.13=51.4 \text{ мян.төг}$
Элэгдлийн зардал	$C_{эхш} = XO_{буль} * H_{э} * t / T_k$ С_{эхш}-элэгдэл хорогдлын шимтгэл H_э-ЭХШ-ийн норм 10%-иар Т_к-жилд ажиллах нийт хугацаа t-хөрс тээвэрлэх ажлын нийт хугацаа	$C_{сз}=170000.0*0.1*23/45.55= 8583.9 \text{ мян.төг}$
Нийт утгуурт ачигчийн зардал	$C_{уд} = C_{дт} + C_{сз} + C_{ц} + C_{ндш} + C_{эхш}$	$C_{уд}=1229.9+8583.9+395.8+51.4+8583.9 = 18844.9 \text{ мян.төг}$
1м ³ хөрсний үеийг ухах ажлын өөрийн өртөг	$C_{э} = C_{нийт,экс} / V_n$	$C_{э} = 18844.9/2.2=8565.8 \text{ мян.төг/м}^3$ $C_{э} = 18844.9/4620= 4070 \text{ төг/м}^3$

Шимт хөрсийг тараан тэгшлэх ажлын зардал

Асгасан шимт хөрсийг тараан тэгшлэх ажлыг бульдозероор гүйцэтгэх ба 1.0 га талбайг тэгшлэх ажлын зардлаар өмнө тооцоолсон үнэлгээг адилтган авъяа. 1.0 га газрыг тэгшлэх ажлын зардал 7852000 төг /га байна.

Энэ нь 2.2 га-д $7852.0 * 2.2 \text{ га} = 17274.4 \text{ мян.төг}$ болох юм

Техникийн нөхөн сэргээлтийн нийт зардал: =

$Z_{ск} = C_{тэгш} + C_{хуч} + C_{тар.тэгш} = 17274.5 + 18844.9 + 17274.4 = 53393.8 \text{ мян.төг}$

1.0 га–д ногдох техникийн нөхөн сэргээлтийн зардал $53393.8 / 2.2 = 24269.9 \text{ мян.төг}$

3.2 Биологийн нөхөн сэргээлт

2025 онд Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн хэмжээнд биологийн 2.2 га талбайд хөдөө аж ахуйн чиглэлээр бэлчээрийн олон наст болох царгас, согоовор, ерхөг, дагуур өлөнгө, хольж тарьсан. Үрийг нормыг MNS 5918:2023 стандартын дагуу 1 га талбайд 70-80 кг байхаар силкээр үрлэсэн.



Зураг 11. Олон настын үрийг хольж силкээр үрлэж буй байдал



Тарьцын төрөл:

Улиас *Populus*- 200 ширхэг

Агч *Acer palmatum* -200 ширхэг



Зураг 11. Олон наст тарьсан талбайд зурвасаар тарилт хийсэн байдал

Ногоон байгууламж:

3.2.1 Ажилчдын хотхоны ногоон байгууламж (Зүлэгжүүлэлт)

2025 онд уурхайн ажилчдын хотхоны орчим ногоон байгууламжыг нэмэгдүүлэх зорилгоор 400м² талбайд зүлэгжүүлэлтийн ажил хийж 320 ширхэг хүрэн монос *Prunus padus 'Colorata'*-ын суулгацыг тарьсан.



Зураг-7. Кемпийн зүлэгжүүлэлтийн ажил хийгдэж буй байдал



Зураг- . Төгөлжүүлэлтийн ажил хийгдэж буй байдал

3.2.2. Засварын төвийн ногоон байгууламж:

2025 онд уурхайн ажилчдын хотхоны орчим ногоон байгууламжыг нэмэгдүүлэх зорилгоор 70 ширхэг өрөл *Malus baccata*-ын суулгацыг тарьсан.

3.2.3 Ажилчдын хотхон орчмын модны арчилгаа/ хамгаалалт/ усалгаа

Мод ургалтын идэвхитэй үед Гумины бордоогоор бордож, мэрэгч болон туулайнаас хамгаалж ажилчдын хотхоны хашаа дагуулан салхины хаалт болгон тарьсан улиасны торнуудыг сэргээх завсарлах нөхөн хамгаалах ажил хийгдсэн. Улирлын арчилгаа, усалгааг календарын дагуу хийсэн бөгөөд хавар, намрын дараа цэнэг усалгааг хийсэн.

НОГООН БАЙГУУЛАМЖИЙН КАЛЕНДАРЬ



№	Цэцэрлэгжүүлэлтийн ажлын жагсаалт	JAN			FEB			MAR			APR			MAY			JUN			JUL			AUG			SEP			OCT			NOV			DEC		
		1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3
1	Үндэсний мод тарих өдөр																																				
2	Хаврын цэнэг усалгаа																																				
3	Хаврын мод тарилт																																				
4	Намрын цэнэг усалгаа																																				
5	Хаврын бага өсөлтийн үе																																				
6	Хавар, зуны их өсөлтийн үе																																				
7	Зуны бага өсөлтийн үе																																				
8	Намрын их өсөлтийн үе																																				
9	Өвөл тайван байдалд байх үе																																				
10	Хаврын талбайн цэвэрлэгээ																																				
11	Хаврын мод сөөгний тайралт, тандалт																																				
12	Хөрс сийрүүлэлт																																				
13	Өдөр тутмын усалгаа																																				
14	Мандлын цэцгийн үрсэлгээ																																				
15	Мандлын цэцэг тарих үе																																				
16	Зүлэг тарилт																																				
17	Зүлэгжүүлэлтийн усалгаа																																				
18	Зүлэг хадалт, хэлбэржүүлэлт																																				
19	Мод хэлбэржүүлэлт																																				
20	Мэргэжлийн зөвлөгөө, сургалт																																				
21	Барилгын хотхоны гадна тохиолт																																				
22	Модны бордооны үе																																				
23	Зүлэгийн бордооны үе																																				
24	Борлогтой мод тарилтын үе																																				
25	Зүлэгийн хаврын усалгаа																																				
26	Хортон шавжаас урьдчилан сэргийлэх																																				

№	Шардлагатай төлөвлөгөө	Тарилтын төрөл	Гүйцэтгэх ажлын төлөвлөгөө	Гүйцэтгэх ажил	Дэмжлэг үзүүлэх урьдчилсан Хариуцагч/Харуулагч	Зогсонг байгуулалтын хэлбэр	Шардлагатай хүч/хүч	Шардлагатай техник	Тогсонтой эхл.	Тогсон /ног/	Aug				Sep				Oct			
											week 4	week 1	week 2	week 3	week 4	week 1	week 2	week 3	week 4	week 1	week 2	week 3
	Креатив төлөвлөгөө	Ажиллагаа үргэлжлэн	Хотхоны ногоон байгууламжийн төлөвлөгөөний үүрэг гэрээлсэн байх	Хотхоны ногоон байгууламжийн төлөвлөгөөний үүрэг гэрээлсэн байх	А.Пироговский, М.Зигурин, Г.Эсхлэватар, О.Эрдэмсүрэн, Д.Дамсүрэн, Б.Энхтүвшин	-	-	-	-	-	-											
1			Талбайг бэлтгэх	Шонг хөрс буулгах, түгшлэх	Г.Эсхлэватар, О.Эрдэмсүрэн, Д.Дамсүрэн, Б.Энхтүвшин	УУТ-тай хамтрах	5	Үйлчилгээний машин	-	-												
2			Бүт сөөг тарих талбайг бэлтгэх	Мод бүт сөөгийг тарих хэлбэр хамаран шулуу, тэгш тарилт үүсгэж байх	А.Пироговский, М.Зигурин, Г.Эсхлэватар, О.Эрдэмсүрэн, Д.Дамсүрэн, Б.Энхтүвшин	УУТ, УАГ-тай хамтрах	-	жижиг экскаватор	-	-												
3			Тархалт суулганы хэмжээг гэрээлэх	Шардлагатай тархалтын хэмжээг гэрээлэх	Д.Дамсүрэн, О.Эрдэмсүрэн, Б.Энхтүвшин	-	-	-	-	-												
4			Тарилтын ажил	Төлөвлөгөөт хайгуур талбайг шийдвэрлэн мод тарих ажлыг зохион байгуулах	М.Зигурин, Г.Эсхлэватар	ЦСАУАГ, УУТ-тай хамтрах	20	Үйлчилгээний машин	-	-												
5			Усалгааны систем суурилуулах	Ногоон байгууламжид тохиромжтой усалгааны систем	О.Эрдэмсүрэн, Д.Дамсүрэн, Б.Энхтүвшин	-	10	Үйлчилгээний машин	-	-												
6			Усалгаа	Бүт сөөг тарих талбайг 5-7 хоногийн дотоотой услах	Д.Дамсүрэн, О.Эрдэмсүрэн, Б.Энхтүвшин	Туслах ажилтан авах	2	Үйлчилгээний машин	-	-												
7			Аричгаа	Мод бүт сөөг хэлбэржүүлэх, тайралт тасалт хийх	Р.Галбаа, Д.Дамсүрэн, О.Эрдэмсүрэн, Б.Энхтүвшин	-	5	Үйлчилгээний машин	-	-												
8			Тархалт суулганы хэмжээг гэрээлэх	Ногоон тарилтат шардлагатай тархалтын хэмжээг гэрээлэх	Д.Дамсүрэн, О.Эрдэмсүрэн, Б.Энхтүвшин	-	-	-	-	-												

Зураг- . Ногоон байгууламж, арчилгааны календарчилсан төлөвлөгөө



Зураг- . Ногоон байгууламж, арчилгааны календарчилсан төлөвлөгөө

Хүснэгт:2 ЦМЭ ХХК тарьсан модны хэмжээ

№	Тарьсан модны байршил	Тарилт хийсэн чиглэл	Модны төрөл	Тоо /ширхэг/
1	Хээр	Отволыг нөхөн сэргээх	Улиас <i>Populus</i>	200
			Агч <i>Acer palmatum</i>	200
		Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Монос <i>Prunus padus 'Colorata</i>	320
			Өрөл <i>Malus baccata</i>	70
Нийт тарьсан мод				790

Биологийн нөхөн сэргээлтийн зардлын тооцоо:

Ойжуулалт/ төгөлжүүлэлтийн ажлын зардал:

$$З_{ур}^o = S_{нс} * Нур * Р_{ур} + З_{ц} * Т * N + З_{тех} + З_{ус} + З_{тээв}$$

$$З_{ур}^o = 2.2 \text{ га} * 790 \text{ ш} * 25000 + 100.0 * 10 \text{ хүн} * 14_{хон} + 1500.0 + 500.0 + 300.0 = 43450.0 + 14000.0 + 2300.0 = 59750.0 \text{ мян.төг}$$

Энд: $З_{ой}$ -ойжуулах ажлын зардал

$S_{нс}$ -биологийн нөхөн сэргээлт хийх нийт талбай, га

$N_{ур}$ —нэгж га талбайд шаардлагатай суулгацын хэмжээ

$P_{мод}$ -нэгж суулгацын зах зээлийн үнэ мян.төг

$З_{ц}$ -нэг ажилчны нэгж хугацааны цалин, мян.төг

T -тариалалтаар ажиллах нийт хоног

N -шаардлагатай ажилчдын тоо

$З_{тех}$ -техникийн зардал мян.төг

$З_{ус}$ -усалгааны ажлын зардал мян.төг

$З_{тээв}$ -тээврийн зардал мян.төг

Хөрс сайжруулах, хамгаалах ажлын зардал

Шимт хөрсний агуулахад байгаа хөрсийг сайжруулахад 1.0 м^3 тутамд 400 төгрөгний зардал гарна гэж тооцоолъё. Тэгвэл:

$$З_{\text{хс}} = 3780 \text{ м}^3 * 400_{\text{төг}} = \mathbf{1512.0 \text{ мян.төг}}$$
 болно.

Ойжуулалт, төгөлжүүлэлтийн нийт ажлын зардал:

$$З_{\text{нийт}} = З_{\text{ой}} + З_{\text{хөрс}} = \mathbf{59750.0 + 1512.0 = 61262.0}$$

Олон наст ургамал тариалалт:

Энэ ажлын хүрээнд олон наст ургамалын үрийг хольж үрлэх ажил хийгдсэн. Энэ ажлын зардлыг томъёолбол:

$$З_{\text{ур}}^0 = S_{\text{нс}} * N_{\text{ур}} * P_{\text{ур}} + З_{\text{ц}} * T * N + З_{\text{тех}}$$

$$З_{\text{ур}}^0 = 2.2 * 80 * 45.0 + 100.0 * 4 * 2 + 500.0 = 7920.0 + 800.0 + 500.0 = \mathbf{9220.0 \text{ мян.төг}}$$

Энд: $З_{\text{р}}$ -ургамалжуулах ажлын зардал,

$З_{\text{ур}}^0$ -бүрхэвч ургамалын үрээр ургамалжуулах ажлын зардал,

$З_{\text{ур}}^1$ -олон наст ургамалын үрээр ургамалжуулах ажлын зардал,

$S_{\text{нс}}$ -биологийн нөхөн сэргээлт хийх нийт талбай, га

$N_{\text{ур}}$ -нэгж талбайд шаардлагатай ургамлын үрийн норм, кг

$P_{\text{ур}}$ -нэг кг ургамлын үрийн зах зээлдэх үнэ

$З_{\text{ц}}$ -нэг ажилчны нэгж хугацааны цалин, мян.төг

T -ургамалжуулах ажлыг хийж гүйцэтгэх хугацаа, хоног

N -ургамалжуулах ажилд ажиллах хүний тоо

$З_{\text{тех}}$ -техникийн зардал

Хөрс сайжруулах, хамгаалах ажлын зардал

Шимт хөрсний агуулахад байгаа хөрсийг сайжруулахад 1.0 м^3 тутамд 400 төгрөгний зардал гарна гэж тооцоолъё. Тэгвэл:

$$З_{\text{хс}} = 22050 \text{ м}^3 * 400_{\text{төг}} = \mathbf{8820.0 \text{ мян.төг}}$$
 болно

$$З_{\text{ур нийт}}^0 = З_{\text{ур}}^0 + З_{\text{хс}} = 9220.0 + 8820.0 = \mathbf{18040.0 \text{ мян.төг}}$$

1 га талбайд ногдох зардал: $18040.0 / 2.2 = 8200.0$ мян.төг

Биологийн нөхөн сэргээлтийн зардлын дүн:

$$З_{\text{бнс}} = З_{\text{ой нийт}} + З_{\text{ур нийт}}^0 = 61262.0 + 18040.0 = 79302.0 \text{ мян.төг}$$

Нийт нөхөн сэргээлтийн зардал:

$$З_{\text{тнс}} + З_{\text{бнс}} = 53393.8 + 79302.0 = 132695.8$$

БҮЛЭГ 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарилгаар Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах Монгол уламжлал, зан заншилаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлийг бууруулах, ой усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж уурхайн шүүрлийн усаар тогтсон хиймэл нуурын эрэг орчимд мод үржүүлэгийн талбайд үржүүлсэн 3000 ширхэг бургас *Salix spp*-ын суулгацыг зурвасаар, намрын тарилтын ажлын хүрээнд 3000 ширхэг агч, голтбор, хайлаасыг тарьсан. Нуурын эрэг дагуу 30000 ширхэг улиас бургас мөчрөөр үржүүлсэн.





Зураг- . Нуур орчмын талбайд төгөлжүүлэлтийн ажил хийгдэж буй байдал

4.1 Мод үржүүлэг/ үрийн нөөц бүрдүүлэлт

2025 онд Улиасны мөчир модлог 5000 ширхэг, Бургасны мөчир модлог 25000 ширхэгийг нийт 30000-ийг мод үржүүлэгийн талбайд үржүүлсэн.

1.Мод үржүүлэгийн талбайн
хөрс боловсруулж буй байдал



2.Үржүүлэгийн талбайд модлог
мөчир үржүүлж буй байдал



Зураг- . Мөчрийн үржүүлэг хийсэн байдал

3.Үржүүлэг хийснээс 7
хоногийн дараах байдал



4.Үржүүлэг хийснээс 14
хоногийн дараах байдал



Зураг- . Мөчрийн үржүүлэг хийсэн байдал

4.Үржүүлэг хийснээс 30
хоногийн дараах байдал



Мөчрийн үржүүлэг ургалт 90%+ хийсэн байдал



Зураг 19. Нөхөн сэргээлтийн бааз, мод үржүүлэг

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын зардал:

$$З_{ур}^o = S_{nc} * Нур * Р_{мод} + З_{ц} * Т * N + З_{тех} + З_{ус} + З_{тээв}$$

$$З_{ур}^o = 1.5 \text{ га} * 6000 \text{ ш} * 10000 + 100.0 * 10 \text{ хүн} * 14_{хон} + 1500.0 + 500.0 + 300.0 = 90000.0 + 14000.0 + 2300.0 = 106300.0 \text{ мян.төг}$$

Энд: $З_{ой}$ -ойжуулах ажлын зардал

S_{nc} -биологийн нөхөн сэргээлт хийх нийт талбай, га

$Нур$ —нэгж га талбайд шаардлагатай суулгацын хэмжээ

$Р_{мод}$ -нэгж суулгацын зах зээлийн үнэ мян.төг

$З_{ц}$ -нэг ажилчны нэгж хугацааны цалин, мян.төг

$Т$ -тариалалтаар ажиллах нийт хоног

N -шаардлагатай ажилчдын тоо

$З_{тех}$ -техникийн зардал мян.төг

$З_{ус}$ -усалгааны ажлын зардал мян.төг

$Z_{\text{тээв}}$ -тээврийн зардал мян.төг

Хөрс сайжруулах, хамгаалах ажлын зардал

Шимт хөрсний агуулахад байгаа хөрсийг сайжруулахад 1.0 м^3 тутамд 400 төгрөгний зардал гарна гэж тооцоолъё. Тэгвэл:

$$Z_{\text{хс}} = 1080 \text{ м}^3 * 400 \text{ төг} = 432.0 \text{ мян.төг болно.}$$

Ойжуулалт, төгөлжүүлэлтийн нийт ажлын зардал:

$$Z_{\text{нийт}} = Z_{\text{ой}} + Z_{\text{хөрс}} = 106300.0 + 432.0 = 106732.0$$

Мөчир үржүүлэгийн ажлын зардал:

$$Z_{\text{үрж}}^o = N_{\text{мөч}} * P_z + Z_{\text{ц}} * T * N + Z_{\text{тех}} + Z_{\text{ус}} + Z_{\text{тээв}}$$

$$Z_{\text{үрж}}^o = 30000 * 500 + 100.0 * 2 \text{ хүн} * 60 \text{ хон} + 1500.0 + 500.0 + 150.0$$

$$= 15000.0 + 12000.0 + 2150.0 = 29150.0$$

ДХ ажлын зардлын нийт дүн:

$$Z_{\text{дх}} = Z_{\text{мод}} + Z_{\text{үрж}} = 106300.0 + 29150.0 = 135450 \text{ мян.төг}$$

БҮЛЭГ 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанд хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг ашигласанаар материаллаг болон эдийн засгийн шилжилт үүсдэг. Материаллаг шилжилт гэдэг нь айл өрх, тэдний өмч хөрөнгө (өвөлжөө, бууц, худаг), эзэмшлийг нүүлгэн шилжүүлэхийг хэлэх бөгөөд төслийн талбайгаас 500 м

дотор амьдардаг айл өрхүүдийг нүүлгэх үйл ажиллагаа юм. Эдийн засгийн шилжилт гэдэгт айл өрхүүд, тэдний мал сүрэг хуучин бэлчрээсээ, худаг уснаасаа алслагдаж нүүхийг хэлнэ.

Бөөрөлжүүтийн талын хүрэн нүүрсний төсөл хэрэгжүүлж буй талбай айл өрх, тэдний эд хөрөнгө байхгүй бөгөөд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа явуулах шаардлагагүй болно.

БҮЛЭГ 6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ

АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн зургадугаар бүлгийн 17 дугаар зүйлийн 10-т заасны дагуу 2012 оны 2 дугаар сарын 18-ны өдөр ШУ-ны академийн археологийн хүрээлэнтэй “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулсаны дагуу Төв аймгийн Баян, Баянжаргалан сумдын нутагт орших Бөөрөлжүүтийн талын төслийн талбай болох тухайн үеийн хайгуулын тусгай зөвшөөрлийн дугаараар 8653Х, 8654Х тоот “Цайдам” 79 га, “Цайдам-1” 9808 га нэртэй хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд доктор Я.Ариунчимэг, Л.Гэрэлцэцэг, Б.Буянтэгш нар палентологийн судалгааг гүйцэтгэн тайлан гаргасан.

Бөөрөлжүүтийн талын төслийн талбайд археологийн урьдчилсан хайгуул судалгаа хийхэд түүх, соёлын дурсгал илрээгүй байна. Харин хайгуулын судалгааны ажлын хүрээнд 122, 105, 162, 146, 147, 125, 111, 112, 104, 164, 176, 171, 187, 189, 194, 190 дугаартай цооногууд дээр палеонтологийн 17 олдвор олдсон байна.

Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор буюу соёлын дурсгалт зүйлийн талаар баримтлах компанийн дотоод журмыг мөрдөж ажилласан.

Хүснэгт-3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Хийгдэх үндсэн ажлууд	Арга хэмжээний хэрэгжилт
Түүх соёлын дурсгалт зүйлс	Төслийн зүгээс бодит бус соёлын өвд үзүүлэх нөлөөллийг бууруулахад уурхайн менежментийн дотоод журмыг мөрдөж ажиллана	Палеонтологи, археологийн олдвор буюу соёлын дурсгалт зүйлийн талаар баримтлах журмыг үндсэн ажилтан болон гэрээт ажилтнуудад танилцуулан хэрэгжилтийг мөрдөж ажилласан. <i>Хавсралт-5. Палентологи, археологийн олдвор буюу соёлын дурсгалт зүйлсийн талаарх баримтлах бодлого.</i>

--	--	--

БҮЛЭГ 7. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Цэцэнс Майнинг энд Энержи ХХК нь Онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр боловсруулан холбогдох газраар батлуулж мөрдөн ажилладаг. Энэхүү төлөвлөгөөнд байгаль орчны болзошгүй аюул ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний талаар дэлгэрэнгүй тусгасан байдаг.

Бөөрөлжүүтийн тал төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулж болзошгүй эрсдэлийг үнэлэхэд Байгаль орчин ногоон хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А-50/378/656 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт “Химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ыг ашиглан гүйцэтгэсэн. Эрсдэлийн үнэлгээгээр дараах тохиолдолд осол, аюул гарч болзошгүй. Үүнд:

- Налуугийн нуралт үүсэх, налуугийн тогтворжилт алдагдах;
- Зам хэсэгчлэн эвдрэх, улмаар зам тээврийн осол гарах;
- Хаягдлын далангын налуу алдагдах; далан сэтэрч аюултай, хортой хаягдал хөрсөнд алдагдах;
- Техник тоног төхөөрөмжүүдийн аюулгүй байдал алдагдах, бензин тос асгарах;
- Эх үүсвэрүүдээс их хэмжээний тоос гарах;
- Гал гарах, тэсэрч дэлбэрэх;
- Цахилгааны шугамын утас тасрах, сулрах.

Аюулгүй ажиллагааг хангах:

Уурхайн бүх үйл ажиллагаа нь “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Хөдөлмөр хамгаалал болон бусад дүрэм зааврын дагуу явагдах бөгөөд түүнийг хатуу чанд мөрдөж ажиллана. Эдгээрээс бөөрөлжүүтийн уурхайд хамаарах нь:

- Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/;
- Гамшгаас хамгаалах тухай хууль;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
- 2003.06.03-ны өдрийн Үйлдвэр, худалдааны сайдын 98 дугаар тушаалын хавсралт. Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм
- MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах. ААН, байгууллага, барилга, байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм;
- MNS 4628:2013 Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 12.104:1994 Хөдөлмөр хамгааллын стандартын систем;
- MNS 5105:2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага

Овоолгын нурулт, тогтворжилтыг хянах:

- Нурах болон гулсаж болзошгүй овоолгуудад анхааруулах тэмдэг байрлуулах;
- Уурхайн усыг байнга шүүрүүлэн хөрс, нүүрсний доголыг усгүй байлгах;
- Үерээс хамгаалах шуудууг байгуулна.

Осол, аюулаас урьдчилан сэргийлэх:

- Техник аюулгүй ажиллагааны дүрмийг хатуу мөрдөж, ажилчдыг аюулгүй ажиллагаанд сургах;
- Байгууламж болон уулын бүх машин техникүүдэд анхны тусламжийн хайрцаг, spillkit буюу химийн бодис асгаралтын үед ашиглах хэрэгсэл суурилуулах;
- Цахилгаан машин, тоног төхөөрөмжтэй ажиллах аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажиллана.

Уурхайн тоосжилттой тэмцэх арга хэмжээ:

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.


Аюулгүй ажиллагаа, онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө:


- Бөөрөлжүүтийн талын ил уурхай нь 2017 оноос ажиллаж эхлэсэн тул болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулан үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.
- Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтанд тогтмол хамруулж, дадлага сургуулилт зохион байгуулсан.

Хүснэгт-4. Эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй болон зайлшгүй эрсдэл	Эрсдэлийн бууруулах, арилгах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Хэрэгжилтийг хариуцах эзэн болон хэлтэс	Зардал (мян.төг)	Холбогдох хууль, эрх зүйн бодлогын зохицуулалт	Баримтжуулалт
Налуугийн нуралт үүссэнээр уурхайн ажилчид бэртэж гэмтэх	Осол гарсан үед хэрэгжүүлэх нарийвчилсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан	Тайлант хугацаанд	ХАБЭАБО-ны хэлтэс, Уул уурхайн хэлтэс	ХАБ-ын зардалд тусгагдсан	-Гамшгаас хамгаалах тухай хууль, Аюулгүй ажиллагааны журам, - Аж ахуй нэгж байгууллагын дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм, - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, - MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	-
Эх үүсвэрүүдээс их хэмжээний тоос гарах	Хуурай улиралд усны машинаар замыг тогтмол усалсан.	Тайлант хугацаанд	ХАБЭАБО-ны хэлтэс, Уул уурхайн хэлтэс	-	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - Агаарын тухай хууль	-
Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэлд өртөх	Байгалийн гэнэтийн аюултай үзэгдлээс учрах эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах	Тайлант хугацаанд	ХАБЭАБО-ны хэлтэс, ХАБ-ын мэргэжилтэн	-	Гамшгаас хамгаалах тухай хууль	-

Хүчтэй шороон шуурганы үед агааржуулагч шороогоор дүүрч, эвдрэх	Агааржуулалтын стандартыг баримтлах, Цэвэрлэгээг тогтмол хийх	-	ААН хэлтэс	Хангамжийн зардал-цэвэрлэгээ тусгагдсан	MNS 5010:2001 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа-Эрүүл ахуй, Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага, - Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавигдах ерөнхий шаардлага	-
Авто машин тээврийн хэрэгслийн осол гарахаас сэргийлэх	Уурхайн замын хурд сааруулагч, тэмдэг, тэмдэглэгээнд үзлэг хийж дутагдал илэрсэн тохиолдолд засаж сайжруулах арга хэмжээ авна.	Улиралд нэг удаа	ХАБ-ын мэргэжилтэн, Уул уурхайн хэлтэс	ХАБ-ын зардалд тусгагдсан	-	
	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, аливаа осол аваргаас урьдчилан сэргийлэх үүднээс шаардлагатай гэж үзвэл замын тэмдэг, тэмдэглэгээг нэмж байрлуулна	Шаардлагатай тохиолдолд	ХАБ-ын мэргэжилтэн, Уул уурхайн хэлтэс	ХАБ-ын зардалд тусгагдсан	-	

Төслийн ажлын талбарууд, зам дээр гарсан аливаа осол аваарыг нэн даруй уурхайн даргад мэдэгдэж, осол бүрийг нарийвчлан шинжилж дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна	Шаардлагатай тохиолдолд	ХАБ-ын мэргэжилтэн, Уул уурхайн хэлтэс	ХАБ-ын зардалд тусгагдсан	-	Төслийн ажлын талбарууд, зам дээр гарсан аливаа осол аваарыг нэн даруй УУГ-ын удирдлагуудад мэдэгдэж, осол бүрийг нарийвчлан шинжилж дахин давтагдахаас урьдчилан сэргийлж ажилласан.
Тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг хангаж үзлэг, засвар, үйлчилгээг тогтмол явуулна	Тайлант хугацаанд	Засварын хэлтэс	УУГ-Засварын хэлтэс	-	
ХАБЭА-ын сургалтаар нийт ажилчдад анхан шатны тусламж үзүүлэх арга зүйн боловсрол олгох сургалтыг шинэ ажилтан бүрт олгодог. Мөн ажлын байрнуудад анхан	Тайлант хугацаанд	ХАБ-ын мэргэжилтэн, Яаралтай тусламжийн алба	5000.0	-	

	шатны эм тариаг байнгын бэлэн байдалд хадгалдаг.					 
Галын аюулаас сэргийлэх	Ажилчдын кемпийн барилга байгууламжийн гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг холбогдох норм, дүрэм журмыг баримтлан хангасан (галын хор, элс, ус нөөцлөх сав гэх мэт)	Тогтмол	Авран хамгаалах алба	ХАБ-ын зардалд тусгагдсан	MNS 5566 : 2020 Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм	 
Нийт зардал			5000.0			

БҮЛЭГ 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ


Цэцэнс Майнинг энд Энержи ХХК нь холбогдох хууль дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах журмыг боловсруулан мөрдөн ажилладаг. Уг журмын дагуу хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал гэж ангилан, хаягдал устгах талбайд булшлах, тусгай шатаагч зууханд шатаах, зориулалтын талбайд цуглуулж уурхайн гадна дахин боловсруулах зэргээр ангилж устгадаг. Одоогоор уурхайн талбайд хог булшлах устгах цэг 1, хаягдал төмөр, хаягдал тос, ашигласан баттерей, хуванцар хаягдал зэргийг тусгай бэлдсэн талбайд ангилан цуглуулж дахин боловсруулах зохих зөвшөөрөлтэй компанид гэрээний дагуу хүлээлгэн өгч байна. Хог хаягдал гаргасны төлбөрийг зохих хуулийн дагуу орон нутагт төлдөг.


Хүснэгт-6. Хог хаягдлыг ангилал, тэдгээрийг устгах аргууд


№	Хог хаягдлын төрөл	Устгах арга	Хаана
1	Ахуйн болон гал тогооны хог хаягдал	Булах	Уурхайн тусгайлан бэлдсэн ахуйн хог хаягдлын цэгт
2	Ахуйн бохир ус	Зориулалтын газар нийлүүлэх	Мааньтын хорих ангийн БУЦБ-д зөөж нийлүүлнэ.
3	Ашиглагдсан, шингээгч материал	Шатаах	Элемент ХХК-тай хийсэн гэрээний дагуу
4	Ашиглагдсан баттерей	Дахин боловсруулах, уурхайн талбайгаас гадна	Уурхайн талбайгаас гаргаж тусгай зөвшөөрөлтэй гэрээт компанид шилжүүлнэ.
5	Хуванцар	Дахин боловсруулах, уурхайн талбайгаас гадна	Уурхайн талбайгаас гаргаж тусгай зөвшөөрөлтэй гэрээт компанид шилжүүлнэ
6	Металл	Дахин боловсруулах, уурхайн талбайгаас гадна	Уурхайн талбайгаас гаргаж тусгай зөвшөөрөлтэй гэрээт компанид шилжүүлнэ
7	Резин	Дахин боловсруулах, уурхайн талбайгаас гадна	Уурхайн талбайгаас гаргаж тусгай зөвшөөрөлтэй гэрээт компанид шилжүүлнэ
8	Хаягдал дугуй	Дахин боловсруулах, уурхайн талбайгаас гадна	Уурхайн талбайгаас гаргаж тусгай зөвшөөрөлтэй гэрээт компанид шилжүүлнэ
9	Хаягдал тос	Дахин боловсруулах, уурхайн талбайгаас	Хаягдал тос боловсруулах үйлдвэр

		гадна	“Ахуй мандал ХХК”
10	Ашиглагдсан унтраагуур гал	Дахин боловсруулах, уурхайн талбайгаас гадна	Уурхайн талбайгаас гаргаж тусгай зөвшөөрөлтэй Гал Импекс компанид шилжүүлнэ.
11	Эмнэлэгийн хаягдал хог	Зориулалтын газар зохих журамын дагуу аюулгүй устгана	Төв аймгийн Баян сумын Нэгдсэн эмнэлэг

Хүснэгт 11. Хог хаягдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Хийгдэх үндсэн ажлууд	Хийгдсэн ажил	Хугацаа ба давтамж	Зарцуулсан зардал (төг)	Хариуцах эзэн	Холбогдох хууль, эрх зүйн бодлогын зохицуулалт	Баримтжуулалт
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	Ахуйн гаралтай хог хаягдал зайлуулах	Төв аймгийн Баян сумтай энгийн хог хаягдлыг төвлөрүүлэх гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажилласан.	2025 оны эхний улиралд багтаан 1 удаа	500.000	БО-ны мэргэжилтэн	Хог хаягдлын тухай /шинэчилсэн найруулга/ 2017, Цэцэнс Майнинг энд Энержи ХХК- ний хог хаяндал ангилах, хадгалах, тээвэрлэх тухай дотоод журам	
	Ахуйн гаралтай хог хаягдал ангилан ялгах савууд нэмэх	Кемп болон засварын төвд 200 литрийн 7 хогийн сав кемпд ангилан ялгах хогийн савуудыг байршуулсан.	Төсөл хэрэгжил тийн явцад	2.000.000	БО-ны мэргэжилтэн, ҮАГ		

Аюултай хог хаягдал	Хог хаягдал цуглуулах,тээвэрлэ х эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээг шинэчлэн байгуулан, биелэлтийг хангаж ажилласан.	Төсөл хэрэгжил тийн явцад	2.000.000	ХАБЭАБО-ны хэлтэс, БО-ны мэргэжилтэн	ХХТХ 23.1, ХХБАБХТАУЖур ам 5.5.5 дахь заалт,	 
	Эмнэлэгийн хог хаягдлыг гэрээний дагуу “Элмент ХХК” -д нийлүүлж акт үйлдэх	Төсөл хэрэгжил тийн явцад	6.000.000			
	Ашигласан тосыг гэрээний дагуу “Элмент ХХК”- дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, акт үйлдэх.	Төсөл хэрэгжил тийн явцад		ХАБЭАБО-ны хэлтэс, БО-ны мэргэжилтэн		

	Хог хаягдлын тоо бүртгэл хөтлөх	Холбогдох маягтын дагуу хог хаягдлын тоо бүртгэлийг тухай бүр хөтөлж тайлангаа улиралд нэг удаа гаргаж үйл ажиллагаа явуулж буй сумын захиргаанд хүргүүлсэн.	Тайлант хугацаанд	-	БО-ны мэргэжилтэн	ХХТХ 23.1, ХХБАБХТАУЖур ам 5.5.5 дахь заалт,	
		Хог, хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах дотоод журмыг үйл ажиллагааны цар хүрээнд нийцүүлэн шинжлэн найруулж боловсруулсан.	1 удаа	-	БО-ны мэргэжилтэн	-	Хог хаягдлыг цуглуулах ангилан ялгах, тээвэрлэх журмыг үйл ажиллагааны цар хүрээнд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулсан.
	Үзлэг шалгалт хяналт	Ахуйн, аюултай хог хаягдлын цэг болон хог хаягдал ангилан цуглуулах талбайд үзлэг шалгалтыг тогтмол хийж үл тохирлыг арилгуулах арга хэмжээг авч ажилласан.	7 хоног бүр	-	ХАБЭАБО-ны хэлтэс, БО-ны мэргэжилтэн	ХХТХ 23.1, ХХБАБХТАУЖур ам 5.5.5 дахь заалт	
Нийт			10500.0 /мян.төг/				

БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

“үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 3.1 дүгээр зүйл, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуульд зааснаар төслийг хэрэгжүүлэх явцад төлөөс байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах гэж нэрлэх бөгөөд энэ нь төсөл хэрэгжиж буй бүс нутагт гарч болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах, үйл ажиллагааны үр дүнг тайлагнах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

Иймд Төв аймгийн Баян сумын нутаг дэвсгэрт байрлах MV-017187, MV-020342 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын тайланг “Дойтын булаг” ХХК -аар гүйцэтгүүлсэн.

БҮЛЭГ 10. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

НҮБ, Төв аймгийн Баянжаргалан сумын ЗДТГ хамтран хэрэгжүүлж буй “Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглал” төслийн хүрээнд уул уурхайн салбарт “Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг” /ХОБОМ/ нэвтрүүлэх арга зүй боловсруулах, уул уурхайн үйлдвэрлэл дээр турших төслийг хэрэгжүүлэхэд “Цэцэнс майнинг энд энержи” ХХК нь 2020 оноос хойш бүхий хугацаанд манлайлж хамтран ажиллаж байгаль орчны бодлогын менежментийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ХОБОМ-ийн арга зүйг илүү практик болгоход мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. Төв аймгийн Баян сумын иргэд, байгаль орчны байцаагчын санал гомдлын дагуу Мааньтаас Бөөрөлжүүтийн уурхай хүртэлх авто зам дээр усалгааг тогтмол хийж, замгүй газраар тээвэр явуулахгүй байх тал дээр хамтран ажиллаж байна. Төв аймгийн Баянжаргалан сумын Жаргалант сумын засаг даргын хүсэлтээр Уурхайн орчимд байрлах нүүрст хонхор гэдэг газар тууварын малчид иргэд хог хаягдалаа маш ихээр хаяж хогийн цэг үүсгэж байсаныг ковшоор дарж хүлээлгэж өгсөн. Мөн Төв аймгийн Баян сумын байгаль орчны байцаагчийн хүсэлтийн дагуу сумны хогийн цэгийг тогтмол дарж хамтран ажиллаж байна.



БҮЛЭГ 11 . БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгахаар тооцож байгаль орчны бодлого зорилтод нийцсэн арга хэмжээнүүдийг авч ажиллахаар зорьсон.

Байгаль орчны менежментийн систем нь байгууллагын үйл ажиллагааг байгальд ээлтэй, тогтвортой байдлаар зохион байгуулахад чиглэсэн нэгдсэн цогц бодлого, зохион байгуулалтын тогтолцоо юм. Энэхүү систем нь олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль, журам, стандартуудын хүрээнд хэрэгжиж, байгаль орчныг хамгаалах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, нөөцийг үр ашигтай ашиглах үндсэн зорилготой.

Бид уул уурхайн компанийн байгаль орчны бодлого болон менежментийн системийг дараах үндсэн чиглэлээр тодорхойлж байна.

Уурхайн байгаль орчны бодлого:

- Монгол улсын холбогдох хууль тогтоомжууд болон олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөнө.
- Байгаль орчныг хамгаалах ажлын гүйцэтгэлийг байнга сайжруулна.
- Нутгийн ард иргэдийн уламжлалт соёл, өв уламжлалыг хүндэтгэж хамгаална.
- Байгаль орчинд халгүй, үйл ажиллагааны үр ашгийг тогтмол дээшлүүлэх шинэ дэвшилтэт технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэхийг эрмэлзэнэ.

Байгаль орчны үйл ажиллагаа

- Байгаль орчны бодлого, менежмент
- Байгаль орчны мониторинг
- Байгаль орчны нөхөн сэргээлт
- Байгаль орчны сургалт, хяналт

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх тусгай график гарган ажиллах. Нөгөөтэйгүүр төлөвлөгөөний биелэлтийг удирдлагын хүрээнд авч үзэж, биелэлтэд нь тогтмол хяналт тавьж ажиллах шаардлагатайн зэрэгцээ энэ асуудлаар байгаль орчны хяналтын байгууллагатай байнгын холбоотой ажиллах хэрэгтэй. Тусгагдсан ажлуудыг жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж хэрэгжүүлж байна.

БО-ны тогтолцооны түвшний доорх 6 журам:

- Мал, ан амьтан зохицуулах журам
- Асгаралтын журам
- Шимт хөрс, хуулах хадгалахтай холбоотой дүрэм журам
- Палентологи, Археологийн олдвор буюу соёлын дурсгалт зүйлийн талаарх баримтлах журам
- Хог хаягдлийг цуглуулах, тээвэрлэх, устгах журам
- Хог хаягдал цэвэрлэх, цэглэх журамууд болно.

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Цэцэнс майнинг энд энержи ххк нь “Бөөрөлжүүтийн тал”-ын төслийн 2025 оны БОМТ-ний хэрэгжилтийн явцыг энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан бо-ны бүрдэл хэсэг тус бүрээр гаргаж, төв аймгийн баян, баянжаргалан сумын здтг/байгаль орчны хяналтын улсын байцаагч болон баян сумын цавчир баг, баянжаргалан сумын жаргалант багийн иргэдийн төлөөлөлд (төслийн талбайд ойр оршин суух малчид)-д жилд 1 удаа тайлагнана. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнасан.

2025 онд төслийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарийг доорх хүснэгтэд үзүүлэв.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар	Сар	Сар		
1	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах.	Тохиролцох		4 сар		ЦМЭ-ийн удирдлага	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
2	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр			11 сар	ЦМЭ-ийн удирдлага	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
3	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг БОАЖЯ-нд хүргүүлж байх, тухайн жилийн БОМТ-г батлуулж байх	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр 12 сард			ЦМЭ-ийн удирдлага	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.12-р заалт, БОАЖ-ын сайдын 2019 оны А/618 тоот тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
4	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Дотоод төлөвлөлтөөр	6 сар			ЦМЭ-ийн удирдлага	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
5	Хөдөлмөрийн эрүүл ахуйн үнэлгээ хийлгэх /хөдөлмөрийн нөхцөлийг үнэлүүлэх/	Гэрээний үнийн дүнгээр			10 сар	ЦМЭ-ийн удирдлага	Хөдөлмөрийн тухай хууль
Нийт дүн		-					

Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлагнасан хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Агуулга	Хугацааны тов	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал (төг)	Хариуцах эзэн	Зохион байгуулах газар	Баримтжуулалт
Баян, Баянжаргалан сумын ЗДТГ, БО- ны байцаагчид Багийн хурал	Танилцуулга, тайлан гаргаж хүргүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг БО-ны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах	Жилд 1 удаа	Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн иргэдийн нийтийн хуралд оролцож үйл ажиллагаагаа танилцуулсан.	1000.0	БО-ны мэргэжил тэн, Орон нутагтай харилцах асуудал эрхэлсэн менежер	Орон нутгийн ЗДТГ	
Иргэдийн төлөөлөл (Төслийн талбайтай ойролцоо нутагладаг Баян сумын Цавчир баг, Баянжаргалан сумын Жаргалант багийн малчин өрхүүд)	Орон нутгийн иргэдийн төлөөллийг уурхайн талбайд хүлээн авч, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах	БОМТ-ний хэрэгжилтийг БО-ны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах	Жилд 1 удаа	Төв аймгийн БОАЖГ, Заамар сумын ЗДТГ, экологийн цагдаагийн газрын хамтран нөхөн сэргээлтийн үйл ажиллагаатай танилцсан.	10000.0		Уурхайн оффист	
Төрийн захиргааны төв байгууллага	Жилийн тайланг хүргүүлж танилцуулах	БОМ Төлөвлөгөөни й биелэлт явц	Жилд 1 удаа	БОУАӨЯ, Ойн газрын ажлын хэсэг 8-р сард хяналт хийсэн.	1000.0	Байгаль орчны мэргэжилтэн	-	

Байгаль орчны ТББ-ууд	БО-той холбоотой мэдээлэлээр хангах	Байгаль орчны талаар тавьсан санал гомдол, хүсэлтэй холбогдох мэдээлэл	-	Тус онд үйл ажиллагаа зогсоосонтой холбоотойгоор дээрх ажил хийгдээгүй болно.	-	Байгаль орчны мэргэжилтэн	-	
БОАЖЯ	Тухайн жилийн тайланг боловсруулан хүргүүлж дараагийн жилийн төлөвлөгөөнд санал авч төлөвлөгөөг батлуулна.	Төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлуудын мэдээлэл	Жилийн эцэст 1 удаа	БОМТ түүний хэрэгжилт	-			
Нийт зардал					12000.0			

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Төслийн Техник эдийн засгийн үндэслэл
2. Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээгээний дүгнэлт
3. Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээний тайлан
4. Төслийн 2025 оны уулын ажлын төлөвлөгөө
5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам / БОАЖЯ-ны сайдын 2019.10.29-ны өдрийн А-618 дугаар тушаал/
6. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал /БОАЖ-ын сайдын 2009.12.29-ний өдрийн 417 дугаар тушаал/
7. Байгаль орчин ногоон хөгжлийн яамны вэб сайт – www.mne.mn
8. Эрдэс баялаг, эрчим хүчний яамны вэб сайт – www.mmre.gov.mn
9. Ашигт малтмалын газрын вэб сайт – www.mrpam.gov.mn
10. Эрхзүйн мэдээллийн сайт – www.legalinfo.mn